

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ СИСТЕМД ОРУУЛАХ ЗАГВАР

ТЕЗ-ийн үр дүн, түүний шалгуур үзүүлэлт **Хөтөлбөрийн үр дүн, түүний төсөл, арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлт**

№	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин /шалгуур үзүүлэлтийн тоон утгаар оруулна./	Гүйцэтгэлийн хувь /хүрсэн, зорилтот түвшний харьцаагаар шууд тооцно./	Төлөвлөсөн үр дүн, төсөл арга хэмжээний биелэлт /2000 тэмдэгтэд багтаан бичнэ, нотлох баримтыг хавсаргана/	Батлагдсан		Санхүүжилтийн			Тайлбар
										Төсөв /төгрөгөөр/	Төсвийн эх үүсвэр	Гүйцэтгэл /төгрөгөөр/	Эх үүсвэр	Гүйцэтгэлийн хувь	
3.2.	Нийгмийн байдал сайжруула.	Төсвийн санхүүжүүлэх зардлын ДНБ-д эзлэх хувь	Хувь	2023	3.6	3.3-аас бага	1.7	100	Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны ертийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 310.7 мянган төгрөг байсныг 2024 онд 803.4 мянган төгрөгт хүргэж 2.6 дахин нэмэгдүүлсэн. Түүнчлэн УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зохицуулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.						
3.2.1.	Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.	Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа	Хувь	2021	33	33	32	100.0	Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны ертийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 310.7 мянган төгрөг байсныг 787.0 мянган төгрөгт хүргэж 2.5 дахин нэмэгдүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Түүнчлэн УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зохицуулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд дундаж тэтгэвэр 803.4 мянган төгрөгт хүрсэн. 2024 оны Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингийн мэдээ гараагүй байгаа байна. 2024 оны 3 дугаар улирлын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг өндөр насны тэтгэвэр авагчдын дундаж тэтгэвэртэй харьцуулахад 32 хувь байна. Улирлын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин жирийн эцсийн дундаж цалингаас өндөр гэдэг. Иймд Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа 2024 оны дундаж цалин гарснаар өсөх боломжтой. Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 689,000 (зурган зуун наян есөн мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572,400 (таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун) төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.				Улсын төсөв		
3.2.1.1.	3.2.1.1.Нийгмийн даатгалын шударга тогтолцоонд шилжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	2022	-	100	100	100	Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалгалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжснээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилүүлэх, тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичигийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл "Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх" -ээр хагас хуримтлалын тогтолцоонд эсэргэцлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчинг бүрдсэн. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих эхэлсэнтэй холбогдуулан 2024 оноос даатгуулагчийн нэрийн дансныг мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг үүсгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогчийн төлөх 1.0%, даатгуулагчийн төлөх 1.0%, нийт 2.0%, мөн сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын 2.0%-ийн шимтгэлийг хуримтлуулж эхэлсэн. Энэ хүрээнд Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж буй 1.2 сая даатгуулагч бүр "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал" -тай болж нийт 214.8 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлалт үүсгэв. "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал" -ын мэдээллээ төрийн үйлчилгээний "E-Mongolia" цахим систем, нийгмийн даатгалын байгууллагын цахим систем portal.ndaatgal.mn болон гар утасны "ndaatgal" аппликейшний хэсгээс харах боломжтой болно.						

3.2.1.2	3.2.1.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл	Хувь	2022	-	-	Дундаж тэтгэвэр 43.3 хувиар өссөн байна.	100	Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023, 2024 онуудад нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 310.7 мянган төгрөг байсныг 787.0 мянган төгрөгт хүргэж 2.5 дахин нэмэгдүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Түүнчлэн УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зориулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 689.000 (зургаан зуун нэвн есөн мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.400 (таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун) төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.	449.2 тэрбум төгрөг	Улсын төсөв	449.2 тэрбум төгрөг	Улсын төсөв	100%
3.2.2.	Зорилгот нийгмийн дээшлүүлнэ.	Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа	Харьцаа	2021	0.9	0.9	0.84	93.3	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан хагас болон бүтэн өнчин хүүхдүүд гэх зэрэг нийгмийн зүгээс анхаарал халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор нийгмийн халамжийн сангаас 65.6 мянган иргэн тэтгэвэр авч байна. Мөн 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээгээр амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж олгодог бөгөөд энэ тэтгэмжид нийт 12.8 орчим мянган хүүхэд хамрагддаг. Нийгмийн халамжийн тэтгэвэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 15.4 хувь буюу 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 375 мянган төгрөг болон нэмэгдүүлсэн. Тэтгэвэр, мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2019 (174.0 мянган төгрөг) онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдэж байна. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2024 оны 04 дүгээр сарыг 01-ний өдрөөс 375,000 төгрөг болон нэмэгдүүлсэн нь амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундаж /448300 төгрөг/-тай харьцуулахад 83.6 хувьтай байна. Мөн 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Уг нэмэгдэлд зарцуулахаар 2025 оны төсөвт 27.5 тэрбум төгрөгийг нэмж баталсан. Нийгмийн халамжийн арга хэмжээнд 2024 оны 12 сарын байдлаар 2,3 их наяд төгрөгийг зарцуулсны дотор нийгмийн халамжийн тэтгэвэрт 61003 иргэнийг хамруулж, 242,6 тэрбум төгрөгийг олгосон байна. Эдгээрийг төрлөөр задалбал: 7362 ахмад настанд 29,4 тэрбум төгрөг, 36623 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 142,5 тэрбум төгрөг, 120 одой иргэнд 0,5 тэрбум төгрөг, 16883 тэжээгч нь нас барсан 18 хүртэл насны хүүхдэд 70,1 тэрбум төгрөг, 15 өрх толгойлсон эх, эцэгт 0,05 тэрбум төгрөг тус тус олгосон байна.				100	
3.2.2.1	3.2.2.1.Зорилтот бүлгийг зөв тодорхойлж, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	Тэтгэврийн нэмэгдэл	Хувь	2022	0.9	0.9		100	Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 16 хүртэл насны хүүхэд, өрх толгойлсон эх, эцэгт нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр олгож байна. Мөн байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч байгаа иргэдэд асаргааны тэтгэмжийг сар бүр олгодог. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын бүлэгт суурилсан аргаар зорилтот бүлгийг тодорхойлон олгож байна. Мөн байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асарч байгаа иргэдэд асаргааны тэтгэмжийг сар бүр олгодог. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын бүлэгт суурилсан аргаар зорилтот бүлгийг тодорхойлон олгож байна. Монгол Улсын Засгийн газар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 375,000 төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг 302,500 төгрөг болон нэмэгдүүлсэн.	242.6 тэрбум	Улсын төсөв	242.6 тэрбум	Улсын төсөв	100
3.2.3.1	3.2.3.1.Төрийн хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	Төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийн хувь	Хувь	2022	26-60		10, 20	100	Төрийн албан хаагчдын үндсэн цалинг инфляцын түвшинтэй (Инфляцын түвшин 2023 оны 08 дугаар сарын байдлаар 10 хувьтай байна) уялдуулан нэмэгдүүлэх зарчмыг баримтлан 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэхээр тооцон Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгалаа. Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэх бөгөөд уг арга хэмжээнд 532.4 тэрбум төгрөг зарцуулсан.			532.4 тэрбум	Улсын төсөв	100
7.3.1.	Гэр бүлийн хүчирхийллийн хохиорчгийн аюулгүй байдал хангагдана.	Нийт үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд, гэр бүлээс үйлчилгээ авсан хүүхэд, гэр бүлийн залзах хувь	Хувь	2022	55	85	85.1	100	Хүүхэд хамгааллын үйлчилгээг 2024 оны 30976 хүүхэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн байна. Кейс шийдвэрлэлтийн дундаж 85.1 хувьтай байна.	193.76 сая	Улсын төсөв	192.3 сая	Улсын төсөв	99.3